

АЗИЙН УЛС ТӨРИЙН ШИНЖЛЭХ УХААНЫ ХӨГЖИЛТ: ТӨЛӨВ БАЙДАЛ, ЧИГ ХАНДЛАГА

Ж.Төртогтох доктор, профессор

МУИС, НШУС, Улс төр судлалын тэнхмийн профессор,

Орчин үеийн улс төрийн судалгааны төвийн эрхлэгч

Энэхүү өгүүллээр улс төрийн шинжлэх ухааны судалгааны нийтлэг арга зүй ба асуудлууд, улс төрийн шинжлэх ухааны нийгэмлэг ба мэргэжлийн сэтгүүл гэсэн үндсэн асуудлын хүрээнд Ази дахь улс төрийн шинжлэх ухааны өнөөгийн хөгжлийн төлөв байдал, цаашдын чиг хандлагыг Япон, Өмнөд Солонгос, Тайланд, Филиппин зэрэг орнуудын жишээн дээр авч үзсэн болно.

Түлхүүр үгс: улс төрийн шинжлэх ухаан, улс төрийн судалгаа, арга зүй, нийгэмлэг, сэтгүүл

Улс төрийн шинжлэх ухааны судалгааны нийтлэг арга зүй ба асуудлууд

Ази дахь улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын хөгжлийн хандлагын талаарх энэ өгүүллээ тус тивийн зарим орнуудад улс төрийн шинжлэх ухааны судалгааны арга зүйн нийтлэг асуудлаар эхлье.

Солонгосын хойгт Японы колоничлол задран унаж, тус улс тусгаар байдлаа олж авсан үеэс эхлэн улс төрийн шинжлэх ухааны хүрээнд өрнөдийн улс төрийн үзэл санаа, институтийг танин мэдэх, судлан шинжлэх томоохон ажлууд эхэлсэн гэж болно. Хэдийгээр Солонгосын хойг тусгаар болоод төдий л удалгүй улс төрийн удирдлага, дэглэмийн хувьд хуваагдан, хоёр тусдаа бүрэн эрх, улс төрийн систем бүхий БНСҮ, БНАСАУ болон задарсан боловч, БНСҮ-д улс төрийн шинжлэх ухааны энэхүү үе шат эрчээ алдаагүй байна. 1961 он хүртэл үргэлжилсэн танин мэдэхүйн шинжтэй хөгжлийн энэ үе шатанд философи, түүхийн болон эрх зүй-институциональ арга зүйн хандлага зонхилж байсан ажээ.

Улмаар дараагийн хоёр арваны туршид Солонгосын дайн, дайнъ: дараах тус улсын эдийн засгийн сэргээн босголт, цаашлаад огцом хөгжлийн эхэн үетэй уялдан улс төрийн шинжлэх ухааны судалгаа шинжилгээ нь улс төрийн бихевиоризмаар тодорхойлогдож байв. Солонгосын улс төрийн шинжлэх ухаанд

энэхүү үеийг форматив (1961-1972) ба сэргэлтийн (1972-1980) үе хэмээн тодорхойлсон байдаг.

Өөрөөр хэлбэл, улс төрийн эрх зүйн болон институциональ аспектын оронд улс төрийн бихевиор ба үйл явцыг системчлэн судлах болсон. Бихевиоризмын нөлөөгөөр эмпирик онолын асуудалд солонгосын улс төр судлалын эрдэмтэд ихээхэн ач холбогдол өгч байжээ. Тухайлбал, форматив үед Америкийн улс төрийн шинжлэх ухаан Солонгосын эрдэмтдийн нийгэмлэгийн үйл ажиллагаа, судалгааны чиглэлд зонхиц ирсэн. Түүнчлэн, системийн шинжилгээ, структур-функциональ хандлага, хөгжлийн модернизаци онол арга зүй дээрх хугацаанд эрчимтэй хөгжсөн нь олон эрдэмтдийн зохиол бүтээлд тусгалаа олжээ.

Улс төрийн шинжлэх ухааны арга зүйн хандлагыг Алмонд “хатуу” ба “зөөлөн” хэмээн хуваан авч үзсэн байдаг (Almond, 1988; 379). Эхнийх нь буюу “хатуу” хандлага нь шинжлэх ухаанд чиглэсэн хандлага юм. Энэ нь улс төрийн талаарх өрөнхий нотолгоо буюу теоремыг боловсруулах, тогтолцоог нь нээх замаар улс төрийг тайлбарлах хандлага юм.

Тэгвэл, 2 дахь хэв маяг нь гуманист, түүхэн, философи, эрх зүйн зэрэг улс төрийн ойлголтууд ба тайлбарыг судалгааны объектоо болгоход голлон чиглэсэн хандлага юм. 1960-аад оны эхнээс бихевиоризмын эхлэлтэй холбоотойгоор энэ хандлага хөгжсөн байдаг.

1980-1988 оны хооронд улс төрийн шинжлэх ухаанд альтернатив хайгуулын үе эхэлсэн гэж болно. Улс төрийн шинжлэх ухаан энэ үед тооны болон чанарын өөрчлөлтөнд орсон байна. Судлаачдын тоо өсөн нэмэгдсэнээс гадна судалгааны үр дүнд ихээхэн ололт, амжилт гарч эхэлсэн. Хамгийн гол нь энэ үед радикал парадигмын нөлөөгөөр улс төрийн бихевиоризмын судалгаанд холбоотой олон янзын судалгааны асуудлууд шинээр гарч ирсэн.

Радикал парадигмд улс төр ба эдийн засгийг хамтад нь авч үзэх хандлага давамгайлдаг. Үүний гол анхааралд капиталист төрийн мөн чанарыг шүүн хэлэлцэхэд төвлөрч байсан. Улс төр судлаачид Веберийн үзэл санаа, сургаалт дахь төрийн үүргийн талаарх санааг дахин авч үзэх, улс төр ба эдийн засгийн хоорондын харилцан үйлчлэлцэлийг дахин судлах марксист бус улс төр эдийн засгийн хандлагын ач холбогдлыг тодруулахад анхаарч байсан.

Улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн дөрөв дэх үе гэж болох тус шинжлэх ухаан эрийн цээнд хүрч эхэлснээс өнөөгийн ардчилсан үе хүртлэх хугацааны үеийг авч үзье. Энэ үед Солонгосын улс төрийн шинжлэх ухаан нь эрдэмтэн судлаачдын явуулж ирсэн судалгааны асуудлууд болон арга зүйн хувьд олон янз болж, бүтээл туурвилийн ургац ч арвин болж ирсэн байна. Дотоод улс төр, харьцуулсан улс төр, олон улсын харилцаа, төрийн удирдлага зэрэг улс төрийн шинжлэх ухааны дэд салбарын хувьд судлаачид хүйтэн дайны дараахь үр нөлөө ба глобальчлал болон Өмнөд, Умард Солонгосын харилцааны өөрчлөлт, хүрээлэн буй орчныг хамгаалах, хүний эрх, төрийн бус байгууллагуудын үйл ажиллагаа,

мэдээллийн хөгжил ба жендерийн тэгш байдал ба анти-терроризм зэргийг пост модерн асуудлуудыг өргөнөөр судлах болжээ.

Түүнчлэн Америк болон баруун Европын улс төрийн шинжлэх ухааны орчин үеийн хөгжлийн жишиг хандлагын дагуу өөрийн орны болон олон улсын үндсэн хуулийн харьцуулсан систем, үндсэн хуулийн онол, арга зүйн асуудлуудыг үндсэн хуулийн эрх зүйн үүднээс төдийгүй улс төрийн шинжлэх ухааны өнцгөөс тухайллан судлах, их дээд сургуульд ордог кредитийг нэмэх зэргээр хөгжих болсон. Мөн ардчиллын үйл явц, төр- иргэний нийгмийн харилцаа, засаглал зэрэг асуудлуудыг дээрх үндсэн судлагдахууны хүрээнд өргөнөөр авч үзэх болжээ.

Японы хувьд үндсэн хуулийн онол, системийн талаарх улс төрийн шинжлэх ухааны тухайлсан судалгаа, шинжилгээ хийх, их сургууль, коллежид хичээл заах зэргийг Солонгосоос хавьгүй өмнө эхлэн хөгжүүлсэн байдаг нь мөн л Америкийн улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн нөлөөтэй холбоотой юм.

1997 оны сүүлчээр тулгарч байсан Солонгосын санхүүгийн хямрал нь улс төр судлаачдын хувьд дотоод улс төр, төрийн бодлого дахь гадаад эдийн засгийн хүчний нөлөөний асуудлыг нарийвчлан судлах шаардлагыг нөхцөлдүүлж ирсэн. Улс төр, засаглалын талаархи философиийн судалгаа ч өсөн цэцэглэж ирсэн. Улс төрийн онол сэтгэлгээ, улс төрийн философиийн салбараар мэргэшсэн хүмүүс нэмэгдэж эхэлсэн.

Ардчилалжилтын судалгаатай холбоотойгоор зарим судлаачид элит ба сонирхлын бүлгүүдийн харилцааны асуудалд илүүтэй анхаарлаа хандуулж байна. Улс төрийн эдийн засгийн салбар судалгааны хувьд, радикал парадигм уналтанд орж, неовеберийн төрийн онол, рациональ сонголтын онол зэрэг бусад хандлагууд хөгжлийн стратеги, эдийн засагт суурилсан улс төрийн өөрчлөлт, төр-зах зээлийн харилцаа, төрийн бодлого төлөвлөлт зэргийг судлах үндсэн арга зүйн зэрэгцээ аналитик арга болон улам хөгжсөн. Иймээс ч Америкийн улс төрийн шинжлэх ухааны нэгэн адил нео-институционализм ч Солонгосын судлаачдын хувьд ач холбогдолтой хэвээр байгаа юм.

Өнөөгийн Тайланд дахь улс төрийн шинжлэх ухааны судалгаа нь засаглал, төрийн удирдлага, олон улсын харилцаа, улс төрийн үйл байдал, улс төрийн институтууд, гадаад бодлого, улс төрийн түүх, улс төрийн сэтгэлгээ зэрэг голчлон Тайландын нөхцөл байдалд тулгуурласан асуудлуудад төвлөрч байна.

1970 –аад оноос өмнөх үеийн улс төрийн судалгаа нь онол- арга зүйн асуудалд түлхүү анхаардаг легал-институциональ хандлагын хүрээнд голчлон явагддаг байжээ (Lowndes, 2002; 12).

Түүхэн болон тайлбарласан анализ улс төрийн шинжлэх ухааны судалгаанд өргөн хэрэглэгддэг байсан. Жишээ нь 1933-1973 оны хооронд бичигдсэн улс төр судлалын магистрын түвшний ажлууд ихэнхдээ тайлбарласан болон онолын хүрээний судалгааны ажил байв. Энэ нь орчин үеийн улс төрийн шинжлэх ухааны хөгжлийн анхан үеийг харуулж байгаагаараа нийтлэг байсан. Эрдэм

шинжилгээний ажилд хандах хандлага ч мөн л арга зүйн энэхүү хүрээнээс хальж чадахгүй 70-аад оныг хүрсэн байна. Ингэхдээ Тайланд ба бусад улс орны хоорондын харилцаа, засаг захиргааны асуудлууд, улс төрийн түүх ба олон улсын эрх зүйн практик асуудлуудыг голчлон авч үзжээ (Sombat and Chulacheeb, 1984: 85).

1969 оны ардчиллын дараа улс төрийн судалгаанд бихевиорист хандлага давамгайлах болсон. Энэ нь 1969-79 оны хооронд хийгдсэн улс төрийн судалгааны ажлын талаас илүү улс төрийн зан байдал, улс төрийн нам, шахалтын бүлэг, улс төрийн соёл, нийгэмшилт, улс төрийн үйл явцын талаар хийгдэж байснаас харагдаж байгаа юм. Тэгвэл 1980-аад оны эхээр гарч ирсэн коммунист дэглэмийн нөлөөгөөр улс төрийн анализын бихевиор хандлагаар судлах явдал багасч иржээ. Энэхүү нөхцөл байдалд улс төр судлаачид төдийгүй ерөөс нийгэм судлаачид Тайландын нийгмийн асуудлууд, хөгжлийн асуудлуудыг түлхүү анхаарч судлах болсон байна.

1990-ээд оноос тус улсад улс төр-эдийн засгийн хосолмол судалгаа ач холбогдолтой болж ирэв. 1990-ээд оны сүүл үеийн эдийн засгийн хямралыг хүртэл Тайланд орон эдийн засгийн хувьд өндөр хөгжилтэнд хүрсэн. Энэ үед олон түмний оролцоо улс төрийн реформд нөлөөтэй болж ирсэн төдийгүй эдийн засгийн асуудлуудыг шийдвэрлэх тал дээр ч энэхүү оролцоо илт нэмэгдсэн байна.

Реформын үр дүн болсон шинэ үндсэн хууль 1997 онд батлагдсанаар хүчтэй гүйцэтгэх засаглалын үе 2000-аад оны эхэн үе хүртэл үргэлжилсэн. Энэ үед улс төрийн шинжлэх ухааны судалгаа ардчилалжилт, сайн засаглал, ардчиллын үе дэх иргэний нийгмийн үүрэг, роль зэрэг асуудалд голчлон чиглэж ирсэн байна.

Дүгнэж хэлэхэд, Тайланд дахь улс төрийн шинжлэх ухаан арга зүйн плюрализмд шилжсэн гэхэд болно. Одоо улс төрийн шинжлэх ухааны судалгаанд олон янзын хандлага, тоон болон чанарын аргууд хэрэглэгдэж байна. Ерөнхийдөө засаглалын харилцааны асуудал аль ч үеийн улс төрийн судалгаанд орхигдолгүй явж ирсэнийг дурьдах хэрэгтэй юм.

Ер нь Азийн улс орнуудад улс төрийн шинжлэх ухаан дараахь дэд салбаруудаар салбарлан хөгжиж байгаа байдал нийтлэг байна. Үүнд:

- улс төр ба төр, засаглал
- олон улсын харилцаа
- төрийн удирдлага буюу нийтийн захиргаа

Ерөнхийдөө сүүлийн хоёроос бусад улс төрийн шинжлэх ухааны салбарууд эхнийхэд хамрагдаж байна гэж болно. Тухайлбал, улс төрийн онол, Үндсэн хуулийн систем, харьцуулсан улс төр зэргийг энд дурьдаж болно. Олон улсын харилцааны салбарын хувьд улс орнуудын гадаад бодлого, олон улсын байгууллага, олон улсын улс төрийн эдийн засаг зэрэг чиглэл харьяалагдаж байна.

Америктай адилгаар төрийн удирдлага нь бодлого хэрэгжилт зэрэг ихэвчлэн төрийн захиргааны секторын бүхий л хүрээг хамрахаас гадна Их сургуулиуд дахь улс төрийн салбарын хувьд хамгийн түгээмэл, эрэлттэй, олон тооны оюутнууд бүхий салбарт тооцогдож төгсөгчид нь ч төрийн болон хувийн секторт ажиллах боломжтой, эрэлттэйд тооцогдож байна.

Улс төрийн шинжлэх ухааны нийгэмлэг ба мэргэжлийн сэтгүүл

Азийн орнуудад улс төрийн шинжлэх ухааны нийгэмлэг, холбоод, их сургууль дахь судалгааны хүрээлэн, төвүүдийг үүсгэн байгуулж ажиллуулж байгаа гол хүчин бол ихэнхидээ эрдмийн чадварлаг хамтлагууд байна. Гэхдээ зарим орнууд тухайлбал Тайландад Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбоо 1970-аад оны эхээр байгуулагдсан боловч энэ байгууллага нь тус улсын улс төр судлаачдыг бүрэн төлөөлдөггүй гэж үздэг. Харин улс төр судлаачид бусад нийгэм судлаачидтай хамтран Тайландын Нийгмийн Шинжлэх Ухааны Холбоог байгуулсан нь 1960 – 80 оны хооронд үйл ажиллагаагаа явуулж байжээ.

Улмаар нийгмийн ухааны олон янзын салбар чиглэлээр янз бүрийн холбоод гарч ирсэнээр дээрх байгууллагын үйл ажиллагааны цар хүрээ хумигдаж иржээ. Түүнээс гадна тус улсад дээрх мэргэжлийн болон судалгааны холбоодоос гадна Их сургуулиуд дахь улс төр судлалын багш нар, улс төр судлалын тэнхимүүд хоорондоо эвлэн нэгдэж зохион байгуулагдан эрдэм шинжилгээ, судалгааны үйл ажиллагаа явуулах нь түгээмэл байдаг.

Японд улс төрийн эвлэл холбоод улс төрийн шинжлэх ухааны дэд салбар тус бүрээр байгуулагдан үйл ажиллагаагаа явуулдаг. Тухайлбал: Японы Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбоо, Японы Олон Улсын Харилцааны Холбоо, Японы Сонгуулийн Судалгааны Холбоо, Японы Харьцуулсан Улс Төрийн Холбоо, Төрийн Бодлого Судлалын Холбоо, Японы Төрийн Удирдлагын Нийгэмлэг, Ази Судлалын Холбоо, Олон Улсын Аюулгүй Байдлын Холбоо, Энх Тайван Судлалын Холбоо зэргийг нэрлэж болно.

Тэгвэл Солонгост улс төрийн шинжлэх ухаан, олон улсын харилцаа, төрийн удирдлагаар үндэсний хэмжээний байгууллагууд ажиллаж байна. Эдгээр нь Солонгосын Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбоо, Солонгосын Олон Улс Судлалын Холбоо, Солонгосын Төрийн Удирдлагын Холбоо юм. Солонгосын Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбоо нь хамгийн эртний бөгөөд том байгууллага нь юм. Солонгосын Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбооны дүрмийн 6-р зүйлд зааснаар дараахь шаардлагын дор хаяж аль нэгийг хангасан хэн боловч тус байгууллагын гишүүнээр элсэх боломжтой байдаг. Үүнд:

Нэгдүгээрт: Улс төрийн шинжлэх ухаан эсвэл холбогдох бусад салбараар докторын зэрэгтэй байх.

Хоёрдугаарт: Их сургууль коллежид улс төрийн шинжлэх ухаан эсвэл холбогдох бусад салбараар хичээл заадаг байх.

Гуравдугаарт: Улс төрийн шинжлэх ухааны чиглэлээр судалгааны ажил хийдэг бие даасан болон их сургуулийн дэргэдэх судалгааны хүрээлэн, төвд ажилладаг байх.

Түүнчлэн Солонгосын Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбооны хөгжилтөнд ач холбогдол бүхий хувь нэмэр оруулсан хүнийг тусгай буюу хүндэт гишүүнээр, магистр, докторын оюутнуудыг хагас гишүүнээр мөн байгууллагын гишүүнчлэлийг зөвшөөрдөг ажээ.

Филиппины хувьд 1962 оны 12-р сарын 05-нд Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбоо нь байгуулагдан анхны Ерөнхийлөгчөөр нь Филиппины Их Сургуулийн улс төрийн шинжлэх ухааны тэнхимийн эрхлэгч доктор Агпало ажилласан. Үүсгэн байгуулагчдын олонхи нь тус тэнхимийн багш нар байсан юм. Үндэсний хэмжээний анхны бага хурлаа 1963 оны 03-р сарын 16-нд “Ардчилал” гэсэн сэдвээр хийж “Ардчилал ба Филиппины соёл”, “Ардчилал ба Филиппины улс төр”, “Ардчилал ба Филиппины гадаад бодлого” зэрэг илтгэлүүдийг хэлэлцэж байжээ (Agpaloo, 1984: 331).

Улмаар *Philippine Political Science Journal* 1974 оны 06-р сараас эхлэн албан ёсоор гарах болжээ.

Филиппины Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбоо байгуулагдсанаасаа хойш 10 гаруй жил үйл ажиллагаа нь зогсонги байж байгаад 1976 онд 2 дахь үндэсний бага хурлаа зохион байгуулжээ. Үүнээс хойш жил бүр үндэсний болон бүсийн хэмжээний бага хурлуудыг зохион байгуулж ирсэн.

Эдгээр хурлууд нь: “Филиппины улс төр ба үндэсний хөгжил”, “Засаглал ба нийгмийн хариуцлага”, “Улс төрийн интеграци”, “Хөгжлийн бодлого”, “Бүс нутгийн төлөвлөлт”, “Улс төрийн болон нийгэм-эдийн засгийн өөрчлөлт, хөгжил” зэрэг сэдвүүдээр зохиогдож байжээ.

Тус Холбооны ихэнхи идэвхитэй гишүүд гадаадад магистр, докторын түвшинд суралцах, зочин профессороор ажиллах, Засгийн газарт ажиллах, Их сургуулийн удирдах ажил хийх болсон зэрэгтэй холбоотойгоор Филиппины Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбоо 1984-88 оны хооронд ямар нэг хурал зохион байгуулагдаагүйгээс гадна мэргэжлийн сэтгүүл эрхлэн гаргах үйл ажиллагаа ч энэ үед зогсож байсан байна.

Солонгосын Улс Төрийн Шинжлэх Ухааны Холбооны албан ёсны сэтгүүл болох *Korean Political Science Review* нь Солонгосын улс төр судлаачдын эрдмийн карьерээ өсгөдөг, өгүүллээ нийтлүүлдэг гол сэтгүүл юм. Мөн Солонгосын Олон Улс Судлалын Холбооны *Korean Journal of International Relations* бол олон улсын харилцаагаар мэргэшсэн судлаачдын хувьд нэр хүндтэй сэтгүүл юм.

Солонгосын Төрийн Удирдлагын Холбооны *Korean Review of Public Administration* нь төрийн удирдлагын салбарын гол сэтгүүлд тооцогддог. Түүнчлэн Сежоны Хүрээлэнгээс эрхлэн хэвлүүлдэг *National Strategy*, Кёнгнамын Их сургуулийн Алс Дорнодын Судалгааны Хүрээлэнгийн *Colsongsoyin ba Dэлхийн Улс төр*, Солонгосын Эрх Зүйн Судалгааны Хүрээлэнгийн *Korea Journal of Legislative Studies* зэрэг улс төр судлалын эрдэмтдийн дунд хүлээн зөвшөөрөгдсөн сэтгүүлүүд байдаг.

Мөн Сөүлийн Үндэсний Их Сургууль, Корей Их Сургууль, Ёнсей Их Сургууль зэрэг Солонгосдоо төдийгүй бус нутаг, олон улсынхан хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн өндөр нэр хүндтэй их сургуулиудын эрдэм шинжилгээний бичиг зэрэг нь судлаач, эрдэмтдийн эрдмийн амжилтыг нотолсон чухал сэтгүүлүүдийн тоонд тооцогддог.

Дээр дурьдсан сэтгүүлүүдийн ихэнх нь гол төлөв солонгос хэл дээр гардаг. Харин *Korean Political Science Review* нь жилд дөрвөн удаа солонгос хэлээр, хоёр удаа англи хэлээр хэвлэгдэн гардаг байна. Кёнгнамын Их сургуулийн Алс Дорнодын Судалгааны Хүрээлэнгийн *Asian Perspective* болон Солонгосын Батлан Хамгаалах Судалгааны Хүрээлэнгийн *Korea Journal of Defense Analysis* зэрэг сэтгүүлүүд зөвхөн англи хэлээр хэвлэгдэн гардагаараа алдартай ажээ.

Харин Тайландын улс төр судлаачдын хувьд эрдэм шинжилгээний бүтээлээ хэвлэн нийтлүүлэх нь тийм ч хурц асуудал биш байсан. Гол сэтгүүлүүд нь Чулалонгкорн Их Сургуулийн *Journal of Social Science*, Таммасат Их Сургуулийн *Journal of Political Science* юм. Ер нь Тайландын ихэнхи сургуулиуд голчлон хичээл заах асуудалд л анхаарах нь түгээмэл учраас багш нарын хувьд ихэнхи цагаа хичээл заах, оюутнуудын ажлыг үнэлж дүгнэх зэрэгт судалгаа хийх эрдэм шинжилгээний өгүүлэл бичихээс илүү цаг зарцуулдаг. Мөн ихэнхи ном бүтээлүүд нь тэдний диссертаци өөрчилж нэмж баяжуулсан бүтээл байдаг байна. Тиймээс Тайландын их сургуулиуд дэлхийн их сургууиудын хөгжлийн чиг хандлагын дагуу судалгаанд суурьлах, эрдэм шинжилгээний бүтээлд ихээхэн ач холбогдол өгч, үнэлж дүгнэх бодлого баримталж эхэлсэнтэй холбоотойгоор шинэ шинэ сэтгүүлүүдийг хэвлэн гаргах, тэдгээрт болон олон улсын бусад нэр хүндтэй сэтгүүлд багш нараа өгүүлэл нийтлүүлэх шаардлага тавьж, энэ чиглэлийг дэмжих болсон ажээ.

Ном зүй

1. Agpalo, Remigio E. 1984. "Philippines," In Takeo Uchida, ed., *Political Science in Asia and Pacific*. Bangkok: UNESCO Office for Education in Asia and the Pacific, 145-182.
2. Almond, Gabriel A. 1988. "Separate Tables; Schools and Sects in Political Science," *PS: Political Science and Politics*. 21 (4), 828-842.

3. Inoguchi, Takashi. 1997. "Democracy and the Development of Political Science in Japan," In David Easton et al. eds., *Regime and Discipline*. Ann Arbor: University of Michigan Press.
4. Kim, Hakjoon. 1990. *Dictionary on Korean Politics*. Seoul: Hangilsa.
5. Lee, Jung-Bock. 1999. "The Growth of Political Science in Korea and Its Future Direction," *Journal of Korean Politics*. 8(9), 549-567.
6. Lowndes Vivien. 2002. "Institutionalism," In David Marsh, and Gerry Stoker, eds., *Theory and Methods in Political Science*. New York: Palgrave, 90-108.
7. Miranda, Felipe B. ed. 1997. *Democratization: Philippine Perspectives*. Quezon City: University of the Philippines Press.
8. Moon, Chung In, and Taehwan Kim. 2002. "International Relations Studies – South Korea," *Journal of East Asian Studies*. 2(1).
9. Sombat, Chantornvong, and Chulacheeb Chinawanno. 1984. "Thailand," In Takeo Uchida, ed., *Political Science in Asia and Pacific*. Bangkok: UNESCO Office for Education in Asia and the Pacific.

Abstract

Political Science in Asia has some common traditional stream called such as historicism and behaviorism. At every stage, political science in Asia has built its distinctive characteristics with the political science community responding to different opportunities provided by contextual factors, for instance the changing nature of political regimes, democratic development and shifting trends of American and Western European political science.

This article explores contemporary political science development tendencies in frame of political science research issues and methodologies as well as political science communities and professional journals in case of Asian countries such as Japan, South Korea, Thailand and the Philippines.